

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/50/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 702723204 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	
4. Аудитын тайлан.....	
4.1 Ерөнхий зүйл	
4.2 Материаллаг байдал	
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	
5. Аудитын илрүүлэлт	
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/130
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Баяндэлгэр сумын хэмжээнд 11-12 сард цасан бүрхүүл тогтож гамшгийн эрсдэл үүссэнтэй холбогдуулан аймгийн онцгой комиссоос 10,000.0 мянган төгрөгийн шатахууны дэмжлэг үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл байхгүй байна. Шинэ хөдөө төслийн хүрээнд тус суманд 90 морины хүчтэй трактор 56,309.1 мянган төгрөг, өвс хаман боогч 48,181.8 мянган төгрөг, үрлүүр 33,463.6 мянган төгрөг, байгалийн хадлан хадах хадуур 24,227.2 мянган төгрөг нийт 162,181.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	89,161,317.58	147,066,693.58
33	АВЛАГА	1,025,013.03	725,013.03
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,025,013.03	725,013.03
35	БАРАА МАТЕРИАЛ	88,136,304.55	146,341,680.55
35400	Хангамжийн материал	70,537,135.55	123,779,511.55
35410	Бичиг хэргийн материал	1,788,478.00	462,934.00
35420	Аж ахуйн материал	28,850,030.80	32,977,320.80
35440	Түлш, шатах тослох материал	486,428.95	6,368,358.95
35450	Барилгын засварын материал	1,736,100.00	2,073,400.00
35460	Хүнсний материал	0	287,200.00
35470	Бусад хангамжийн материал	37,676,097.80	81,610,297.80
35600	Мал амьтад	17,599,169.00	22,562,169.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	882,659,380.31	1,178,754,844.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	882,659,380.31	1,178,754,844.06
39200	Биет хөрөнгө	849,490,772.15	1,138,871,902.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,002,913,935.68	1,042,913,935.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	-337,770,770.47	-375,434,158.11
39203	Авто-тээврийн хэрэгсэл	194,751,255.00	282,755,145.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-140,058,212.75	-156,525,254.75
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	102,783,517.62	234,681,981.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	-71,409,671.45	-80,797,664.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,237,810.96	26,637,810.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,198,647.28	-22,508,660.79
39214	Бусад үндсэн хөрөнгө	161,479,622.00	262,888,529.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-68,238,067.16	-75,739,761.66
39300	Биет бус хөрөнгө	33,168,608.16	39,882,941.63
39301	Програм хангамж	1,245,510.00	3,095,510.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,072,901.84	-1,208,568.37
39303	Бусад биет бус хөрөнгө	32,996,000.00	37,996,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	971,820,697.89	1,325,821,537.64
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	450	1,025,220.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	450	1,025,220.00
41300	Өглөг	450	1,025,220.00
41360	Бусад өглөг	450	1,025,220.00
41361	Байгууллагад төлөх өглөг	450	1,025,220.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	971,820,247.89	1,324,796,317.64
51	Засгийн газрын хувь оролцоо	971,820,247.89	1,324,796,317.64
51100	Засгийн газрын оруулсан капитал	144,833,442.83	144,833,442.83
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	144,833,442.83	144,833,442.83
51200	Хуримтлагдсан үр дүн	400,508,092.62	753,484,162.36
51210	Өмнөх үеийн үр дүн	387,260,941.73	400,508,092.61
51220	Тайлант үеийн үр дүн	13,247,150.89	352,976,069.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	426,478,712.44	426,478,712.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	971,820,697.89	1,325,821,537.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	546,109,122.63	860,982,061.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	88,459,750.00	392,682,351.00
120	Нийтлэг татварын бус орлого	88,459,750.00	392,682,351.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0	100,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	81,171,300.00	354,231,361.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,288,450.00	38,350,990.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	457,649,372.63	468,299,710.13
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,795,472.63	74,616,810.13
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	11,097,147.00	23,942,693.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	60,698,325.63	50,674,117.13
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	385,853,900.00	393,682,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн	385,853,900.00	393,682,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	530,800,776.84	508,005,991.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	505,915,476.84	492,764,127.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,673,362.13	391,087,712.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,204,243.34	147,163,614.59
210101	Үндсэн цалин	132,037,870.72	124,763,382.71
210102	Нэмэгдэл	33,263,468.04	14,851,718.29
210104	Урамшуулал	0	7,548,513.59
210105	Гэрээт ажлын хөлс	37,902,904.58	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	26,076,974.06	19,390,946.99
210201	Тэтгэврийн даатгал	18,651,853.50	13,635,689.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,890,202.95	1,466,807.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,512,102.48	1,173,445.55
210204	Ажилгүйдлийн даатгал	354,858.34	268,458.03
210205	Эрүүл мэндийн даатгал	3,667,956.79	2,846,546.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,484,213.39	42,487,704.22
210301	Гэрэл, цахилгаан	2,915,911.39	2,906,284.22
210302	Түлш, халаалт	36,568,302.00	39,581,420.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,654,505.63	13,687,706.80
210401	Бичиг хэрэг	3,132,626.00	2,605,097.00
210402	Тээвэр, шатахуун	8,994,250.00	9,164,010.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,932,629.63	1,918,599.80
210404	Ном, хэвлэл	139,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	1,456,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250,000.00	0
210604	Урсгал засвар	250,000.00	0
2107	Томилолт, зочны зардал	1,006,000.00	4,496,000.00
210702	Дотоод албан томилолт	1,006,000.00	4,496,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	1,893,469.00	17,945,303.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	697,369.00	16,898,907.68
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	163,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,100.00	275,046.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	176,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,103,956.71	145,916,435.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,468,685.46	73,323,972.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,557,271.25	72,592,463.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,242,114.71	101,676,415.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,426,700.00	19,404,900.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	0	101,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	4,379,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,426,700.00	14,026,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	897,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад	65,815,414.71	82,271,515.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,815,414.71	82,271,515.15
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,885,300.00	15,241,864.17
2200	Дотоод эх үүсвэрээр	24,885,300.00	15,241,864.17
221001	Их засвар	24,885,300.00	15,241,864.17
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	15,308,345.79	352,976,069.75
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,061,194.90	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	986,194.90	0
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	1,075,000.00	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-	13,247,150.89	352,976,069.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	457,649,372.63	468,716,310.13
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	457,649,372.63	468,716,310.13
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,795,472.63	75,033,410.13
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	11,097,147.00	23,942,693.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	60,698,325.63	51,090,717.13
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	385,853,900.00	393,682,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн	385,853,900.00	393,682,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	421,061,622.63	428,954,820.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	421,061,622.63	428,954,820.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,819,507.92	327,278,404.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,204,243.34	150,349,317.73
210101	Үндсэн цалин	132,037,870.72	119,339,237.86
210102	Нэмэгдэл	33,263,468.04	16,947,387.98
210104	Урамшуулал	0	14,062,691.89
210105	Гэрээт ажлын хөлс	37,902,904.58	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,076,974.06	18,586,439.24
210201	Тэтгэврийн даатгал	18,651,853.50	12,714,919.38
210202	Тэтгэмжийн даатгал	1,890,202.95	1,495,872.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,512,102.48	1,196,698.40
210204	Ажилгүйдлийн даатгал	354,858.34	274,270.99
210205	Эрүүл мэндийн даатгал	3,667,956.79	2,904,677.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,484,213.39	42,059,084.22
210301	Гэрэл, цахилгаан	2,915,911.39	2,906,284.22
210302	Түлш, халаалт	36,568,302.00	39,152,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,655,683.63	12,323,152.80
210401	Бичиг хэрэг	2,809,804.00	1,404,553.00
210402	Тээвэр, шатахуун	8,994,250.00	9,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,996,629.63	1,918,599.80
210404	Ном, хэвлэл	159,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	2,696,000.00	0
2105	Нормативт зардал	240,000.00	240,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	240,000.00	240,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,499,960.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,499,960.00
2107	Томилолт, зочны зардал	1,006,000.00	4,496,000.00
210702	Дотоод албан томилолт	1,006,000.00	4,496,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	2,030,007.00	23,492,493.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	697,369.00	22,446,097.99
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	163,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	296,638.00	275,046.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	176,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,622,386.50	74,231,957.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,544,386.50	74,231,957.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,242,114.71	101,676,415.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,426,700.00	19,404,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	4,379,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,426,700.00	14,026,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	999,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	65,815,414.71	82,271,515.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,815,414.71	82,271,515.15
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-	36,587,750.00	39,761,490.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	36,587,750.00	39,761,490.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,587,750.00	39,761,490.00
2200	Дотоод эх үүсвэрээр	36,587,750.00	39,761,490.00
223001	Бусад хөрөнгө	36,587,750.00	23,911,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	15,849,890.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-36,587,750.00	-39,761,490.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	144,833,442.83	426,563,804.15	387,175,850.03	958,573,097.01
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	85,091.70	85,091.70
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	144,833,442.83	426,563,804.15	387,260,941.73	958,658,188.71
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-85,091.70	0	-85,091.70
9	Тайлант үеийн үр дүн	0	0	13,247,150.89	13,247,150.89
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	144,833,442.83	426,478,712.44	400,508,092.62	971,820,247.89
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	144,833,442.83	426,478,712.44	400,508,092.62	971,820,247.89
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	144,833,442.83	426,478,712.45	400,508,092.61	971,820,247.89
19	Тайлант үеийн үр дүн	0	0	352,976,069.75	352,976,069.75
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	144,833,442.83	426,478,712.45	753,484,162.36	1,324,796,317.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	393,266,300.00	329,655,987.98	63,610,312.02	83.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	354,466,300.00	289,894,497.98	64,571,802.02	81.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	339,440,000.00	274,869,197.98	64,570,802.02	80.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,701,900.00	150,349,317.73	51,352,582.27	74.54
210101	Үндсэн цалин	163,773,500.00	119,339,237.86	44,434,262.14	72.87
210102	Нэмэгдэл	37,928,400.00	16,947,387.98	20,981,012.02	44.68
210104	Урамшуулал	0	14,062,691.89	-14,062,691.89	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	27,230,000.00	18,586,439.24	8,643,560.76	68.26
210201	Тэтгэврийн даатгал	19,161,800.00	12,714,919.38	6,446,880.62	66.36
210202	Тэтгэмжийн даатгал	2,017,000.00	1,495,872.80	521,127.20	74.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,613,700.00	1,196,698.40	417,001.60	74.16
210204	Ажилгүйдлийн даатгал	403,400.00	274,270.99	129,129.01	67.99
210205	Эрүүл мэндийн даатгал	4,034,100.00	2,904,677.67	1,129,422.33	72.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,059,100.00	42,059,084.22	15.78	100.00
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,906,284.22	93,715.78	96.88
210302	Түлш, халаалт	39,059,100.00	39,152,800.00	-93,700.00	100.24
2104	Хангамж, бараа материалын зардал	12,926,100.00	12,323,152.80	602,947.20	95.34
210401	Бичиг хэрэг	1,405,000.00	1,404,553.00	447.00	99.97
210402	Тээвэр, шатахуун	9,001,100.00	9,000,000.00	1,100.00	99.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,520,000.00	1,918,599.80	601,400.20	76.13
2105	Нормативт зардал	240,000.00	240,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	240,000.00	240,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,499,960.00	40.00	100.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,499,960.00	40.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	5,579,000.00	4,496,000.00	1,083,000.00	80.59
210702	Дотоод албан томилолт	5,579,000.00	4,496,000.00	1,083,000.00	80.59
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	24,997,300.00	23,492,493.99	1,504,806.01	93.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	23,631,300.00	22,446,097.99	1,185,202.01	94.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	163,350.00	286,650.00	36.30
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	275,046.00	24,954.00	91.68
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	184,000.00	176,000.00	8,000.00	95.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,206,600.00	21,822,750.00	1,383,850.00	94.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,206,600.00	21,822,750.00	1,383,850.00	94.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,026,300.00	15,025,300.00	1,000.00	99.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,026,300.00	15,025,300.00	1,000.00	99.99
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	14,026,300.00	14,026,300.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	999,000.00	1,000.00	99.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,800,000.00	39,761,490.00	-961,490.00	102.48
223001	Бусад хөрөнгө	38,800,000.00	39,761,490.00	-961,490.00	102.48
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	393,266,300.00	393,682,900.00	-416,600.00	100.11
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	354,466,300.00	393,682,900.00	-39,216,600.00	111.06
320001	Орон нутгийн төсвөөс	354,466,300.00	393,682,900.00	-39,216,600.00	111.06
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ	38,800,000.00	0	38,800,000.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	38,800,000.00	0	38,800,000.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,795,472.63	75,033,410.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	71,795,472.63	75,033,410.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,929,931.50	52,409,207.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	697,369.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	697,369.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,232,562.50	52,409,207.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,154,562.50	52,409,207.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	4,379,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	4,379,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	4,379,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	18,244,603.13
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	0.00	18,244,603.13
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	71,795,472.63	75033410.13
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,795,472.63	75,033,410.13
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	11,097,147.00	23,942,693.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	60,698,325.63	51,090,717.13
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь сумын төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, төр эдийн засаг нийгмийн бодлогын удирдлага үйл ажиллагааг оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын харьяа төрийн байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төрийн албаны тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн А/24 тоот “Дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай” тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй томилогдсон байна.

Дотоод хяналт шалгалт хийх 7 арга хэмжээ төлөвлөж батлуулсан ч хяналт шалгалтын ажил хийгдээгүй байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь 2013 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/13 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 354,000.8 мянган төгрөгөөр буюу 36,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Авлага	1,025.0	725.0	(300.0)
Бараа материал	88,136.3	146,341.7	58,205.4
Нөөцийн бараа	-	-	-
Үндсэн хөрөнгө	882,659.4	1,178,754.8	296,095.5
Нийт хөрөнгө	971,820.7	1,325,821.5	354,000.8
Өр төлбөр	0.5	1,025.2	1,024.8
Засгийн газрын хувь оролцоо	971,820.2	1,324,796.3	352,976.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө	971,820.7	1,325,821.5	354,000.8

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага дансны эхний үлдэгдэл 1,025.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 725.0 мянган төгрөг болж 300.0 мянган төгрөгөөр авлага буурсан байна.

Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 88,136.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 146,341.7 мянган төгрөг буюу 58,205.4 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал 43,934.2 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 5,881.9 мянган төгрөг, аж ахуйн материал 4,127.3 мянган төгрөг тус тус өссөнөөс шалтгаалсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 882,659.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,178,754.8 мянган төгрөг болж, 296,095.5 мянган төгрөгөөр өссөн нь Шинэ хөдөө төслөөр 162,181.8 мянган төгрөгийн трактор, тоног төхөөрөмж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 31,694.8 мянган төгрөгийн хогны машин, Байдлаг болон Галуут багт бэлчээрийн худаг 40,000.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө дансанд 108,834.7 мянган төгрөгийн камер, гэрэлтүүлэг, хөшөө, Нацагдоржийн хашааны сандал, явган хүний зам, төсвийн хөрөнгөөр 15,449.9 мянган төгрөгийн зөөврийн компьютер, принтер, бусад 11,920.0 мянган төгрөгийн хөрөнгө орлого авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,324,796.3 мянган төгрөг болж 352,976.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 407,373.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 14,107.6 мянган төгрөгөөр бууруулан 393,266.3 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлан ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 14,107.6 мянган төгрөгөөр бууруулан 393,266.3 мянган төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг 393,266.3 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 393,682.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 64,026.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 329,239.4 мянган төгрөг буюу 83,7 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласнаас цалин, шимтгэлийн зардал 59,996.0 мянган төгрөгөөр зарцуулагдаагүйтэй холбоотой байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 27 арга хэмжээ батлагдаж 95,2%-тай хэрэгжиж дүгнэгдсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70106-80101	259,145.7	210,001.0	49,144.7	81.0
2	70106-80103	43,418.3	35,704.8	7,713.5	82.2
3	70106-80106	26,876.0	20,364.2	6,511.8	75.8
4	70106-80802	15,026.3	15,025.3	1.0	100.0
5	70106-80918	38,800.0	38,360.9	439.1	98.9
6	70106-81102	5,000.0	4,841.2	158.8	96.8
7	70106-82801	5,000.0	4,942.0	58.0	98.8
	Дүн	393,266.3	329,239.4	64,026.9	83.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 27 арга хэмжээ батлагдаж 95,2%-тай хэрэгжиж дүгнэгдсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд Төв Чандмань ДЭХГ-аас 1,524.0 мянган төгрөгийн ундны усны нөхөн төлбөр, хуулийн дагуу сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчдын 4,379.6 мянган төгрөгийн тэтгэмж, аймгийн Засаг даргын 2022 оны №А/222 тоот захирамжаар малын гоц халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх шатахууны зардалд 971.0 мянган төгрөг, мөн №А/729 тоот захирамжаар өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан 10,000.0 мянган төгрөг шатахууны зардал, Статистикийн хэлтсээс ХАА-н тооллогын урамшуулал 3,348.1 мянган төгрөг, Чулуут интернейшнл ХХК-аас 3,000.0 мянган төгрөгийн хандив, 2021 оны эцэст төвлөрүүлсэн буцаан олголт 37,865.5 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлого 7,700.0 мянган төгрөг, бусад орлого 6,245.2 мянган төгрөг нийт 75,033.4 мянган төгрөгийн орлого нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 4,379.6 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 52,409.2 мянган төгрөг зарцуулж, 18,244.6 мянган төгрөгийг орон нутагт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Төр засгийн бодлого шийдвэрийг сурталчилж хэрэгжилтийг хангах, иргэдэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй чанартай хүртээмжтэй хүргэнэ.	83.7	393,266.3	329,239.4
Нийт дүн				83.7	393,266.3	329,239.4

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зөвлөмж өгөгдсөн болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №03/27 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны 393,266.3 мянган төгрөгийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 5,314.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,985.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тооцохдоо өмнөх оны батлагдсан төсөвтэй тайлант оны батлагдсан төсвийг харьцуулан дүн шинжилгээ хийхэд 23,443.2 мянган төгрөгөөр батлагдсан төсөв буурсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд мэдээлсэн байдлын хэрэгжилт 80.0%-тай, мэдээллийг байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж 28,962.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 2,700.0 мянган төгрөгийн 26,262.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар халаалтын талбайн хэмжээ зөрүүтэй байсан зөрчлийг арилгаагүйгээс 2021 онд 4,292.6 мянган төгрөгийг илүү олгосон, нийт 4,497.4 мянган төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн сангаас олгосон, Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын А/72 дугаар болон А/128 дугаар захирамжаар 1,500.0 мянган төгрөг ирүүлснийг зарцуулаагүй, Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар ажиллагчидтай холбогдсон 1,025.0 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчилд төлбөрийн акт, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг харилцагч байгууллагын НӨАТ-ийн цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 93,613.4 мянган төгрөгийн гүйлгээ баталгаажуулаагүй, телевизийн бичлэг хийсэн ажлын хөлсөнд 440.0 мянган төгрөг, аймгийн номын сангаас Нацагдоржийн 110 жилийн ойн түүхэн кино бүтээхэд 750.0 мянган төгрөг, Төв түмний мэнд нэвтрүүлгийн төлбөрт 70.0 мянган төгрөг, нийт 1,260.0 мянган төгрөг шилжүүлсэн, тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаа хоцроосон 43, огт байршуулаагүй 8 мэдээлэл байсан зэрэг зөрчилд албан шаардлага өгч, Хөрөнгийн тооллогыг эд хөрөнгийн тооллогын бүртгэл маягтын дагуу хийгээгүй, тооллогын комиссын бүртгэлийг баталгаажуулан тооцоо бодоогүй зөрчилд зөвлөмж өгсөн байна. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 97,9 % хэрэгжүүлэн Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 06/153 тоот албан бичгээр хэрэгжилтийг гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	4	11,315.0	4	10,590.0	93.6
Албан шаардлага	3	107,738.2	3	107,738.2	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	8	119,053.2	8	118,328.2	97.9

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын зарцуулалтаас шатахуун зардал, тооцоо бодолтыг нарийвчлан шалгах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 83,664.8 мянган төгрөгийн алдаа¹ залруулагдсан болно.

Залруулсан алдаа

Илрүүлэлт: Үнэ төлбөргүй авсан хөрөнгийг 83,664.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 36,302.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 19,106.0 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт, 17,196.7 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн.

Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансанд 2019-2020 онд газрын дуудлага худалдааны ялагчийн дэнчин 8,817.1 мянган төгрөг, 2022 оны газрын дуудлага худалдааны орлого аймгаас хуваарилагдсан 7,700.0 мянган төгрөг нийт 16,517.1 мянган төгрөгийг газрын төлбөрийн дансанд төвлөрүүлээгүй байна. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8-д “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.14-д “газрын төлбөр”, 23.11-д “Газар, байгалийн баялгийн нөөцийг хуульд заасан хэлбэрээр эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого нь төсвийн орлого байна” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

2. Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй олгосон.

Илрүүлэлт: Тусдаа төсөвтэй босоо удирдлагатай төсвийн байгууллагын ажилтнуудыг үүнд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ажилтан, Байгаль хамгаалагч нарт 339.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй олгосон.

Илрүүлэлт: Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын өдрийн арга хэмжээний зардалд 1,000.0 мянган төгрөг зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

4. Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй олгосон.

Илрүүлэлт: Шүлхий гарсантай холбогдуулан аймгийн Онцгой комиссоос шатахууны зардал олгосон байхад нэмж хувийн Мал эмнэлгийн газарт 600.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

5. Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй олгосон.

Илрүүлэлт: ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ажилтаны Удирдлагын академийн сургалтын төлбөрт 650.0 мянган төгрөг төлсөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Малын бүртгэлийг тооллогын бүртгэлээс зөрүүтэй, ОНХС-гийн хөрөнгөөр авсан хуц, ухна, бухыг гэрээгээр эзэмшүүлсэн гэх боловч хэнд байгаа нь тодорхойгүй, гэрээг дүгнэсэн баримтгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.5-д “мал, амьтныг

эзэмшигч бүрээр тоолоход бэлтгүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй ОНХС-ийн хөрөнгөөр авсан хуц, ухна, бухыг гэрээг эзэмшүүлсэн байгааг дүгнэж, жил бүр шинэчлэн гэрээг анхан шатны баримтад хавсаргаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ОНХС-гийн хөрөнгөөр авсан малыг гэрээгээр эзэмшүүлсэн гэх боловч хэнд байгаа нь тодорхойгүй, гэрээг дүгнэсэн баримтгүй байна.	1	17,196.7	1	17,196.7	-	-	-	-	-	-	-	-
ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ажилтаны Удирдлагын академийн сургалтын төлбөрт 650,0 мянган төгрөг төлсөн.	1	650.0	1	650.0	-	-	-	-	-	-	-	-
Тусдаа төсөвтэй босоо удирдлагатай байгууллагын ажилтнуудад 339,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон	1	339.0	1	339.0	-	-	-	-	-	-	-	-
Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын өдрийн арга хэмжээнд 1000.0 мянган төгрөг зарцуулсан.	1	1,000.0	1	1,000.0	-	-	-	-	-	-	-	-
Шүлхий гарсантай холбогдуулан АОК- оос шатахууны зардал олгосон ч нэмж хувийн МЭГ-т шатахуун олгосон байна.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	-	-
Нэмэлт санхүүжилтийн дансанд газрын дуудлага худалдааны орлого нийт 16.517.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн	1	16,517.0	-	-	-	-	1	16,517.0	-	-	-	-
Нийт дүн	6	36,302.7	5	19,785.7	-	-	1	16,517.0	-	-	-	-